

Маягт СЗХ04008

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

|  |   |  |      |            |    |             |    |
|--|---|--|------|------------|----|-------------|----|
| 1  | Мэдэгдэл огноо  | Он   | 2021 | Сар        | 03 | Өдөр        | 29 |
| 2  | Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр   | Амар Даатгал ХХК   |      |            |    |             |    |
| 3  | Даатгалын бүтээгдэхүүний нэр  | Орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн                 |      |            |    |             |    |
| 4  | Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр                         | Хөрөнгийн даатгал  |      |            |    |             |    |
| 5  | Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр | Шийдвэрийн нэр   |      | Огноо      |    | Дугаар      |    |
|  |   | Шинэ хэлбэр болон бүтээгдэхүүнээр үйл ажиллагаа эрхлэх тухай |      | 2018-09-05 |    | ЗТ-481-2018 |    |
| 6  | Цахимаар борлуулах эсэх   | Тийм   |      |            |    |             |    |
| 7  | Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:                                    | Овог   |      | Нэр        |    |             |    |
|  |   | Доржготов  |      | Уранцэцэг  |    |             |    |
| <b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>            |   |  |      |            |    |             |    |
| 8  | Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх  |  |      |            |    |             |    |
| <b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b> |   |  |      |            |    |             |    |
| 9  | Даатгалын зүйл  | Бүх төрлийн орон сууц  |      |            |    |             |    |
|  | Даатгалын үндсэн эрсдэл   | Гал, цахилгаан, сантехник, байгаль, гуравдагч этгээд         |      |            |    |             |    |
|  | Даатгалын нэмэлт эрсдэл   | Цэвэрлэгээ, нүүлгэлт, бусад                                  |      |            |    |             |    |
|  | Даатгалын хураамжийн хувь, хэмжээ   | 0.06%-0.6%   |      |            |    |             |    |

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

**ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД**

1. Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол болох орчин нөхцөлийг санаатай бүрдүүлсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотлогдсон;

2. Даатгалын хураамжийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй;
3. Даатгуулагч даатгагчид даатгалын зүйл болон хохирлын талаар худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
4. Даатгалын зүйлийн даатгалын эрсдэлд хамрагдахгүй тохиолдлын улмаас хохирол учирсан;
5. Газар хөдлөлт, түүний үр дагавар;
6. Учирсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;
7. Даатгуулагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр даатгалын тохиолдол болсноос хойш 72 цагийн дотор даатгагчид мэдэгдэх болон даатгалын нөхөн төлбөрийн материалаа тохиолдол болсноос хойш 90 хоног дотор багтаан хүлээлгэн өгөх үүргээ биелүүлээгүй;
8. Даатгуулахаас өмнө учирсан хохирол, хор нөлөөг арилгаагүй;
9. Нотлох боломжгүй болсон хохирол;
10. Хэвийн элэгдэл хорогдол, цагийн урсгалаар үйлчлэл үзүүлдэг хүчин зүйлсээс шалтгаалсан агшилт, жин алдалт, бохирдолт, өнгө, загвар хийцийн өөрчлөлт;
11. Алдаатай болон буруу зураг төсөл, загвар ашигласан эсвэл чанарын шаардлага хангахгүй материал хэрэглэсэн, зураг төслийг өөрчилсөн;
12. Үйлдвэрлэлийн дефектээс болон буруу суурилуулсан, угсарсан, задалснаас үүдэн гарсан болон тэдгээрийг засварласан аливаа зардал;
13. Шалган турших зорилгоор эсвэл санаатайгаар ачаалал хэтрүүлэх болон хэвийн бус байдал бий болгосон аливаа тохиолдлоос үүссэн хохирол;
14. Барилга байгууламж ашиглахтай холбоотой хууль тогтоомж зөрчих, зураг төслөөр тогтоосон хэмжээнээс давсан ус, дулаан, эрчим хүч хэрэглэх, инженерийн шугам сүлжээнд хэт ачаалал өгөх, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр болон харилцан тохиролцоогүйгээр өөрийн эзэмшлийн бус барилга байгууламжийн инженерийн хангамжийн хэрэглээг таслах, тухайн барилгын орчны тохижилтыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөх, өргөтгөл, шинэчлэлт болон их засварын ажил хийгдсэн барилга байгууламжийг зохих ёсоор ашиглалтад оруулаагүй тохиолдолд ашиглахтай холбоотой үүссэн хохирол;
15. Барилгын тухай хуульд заасан хугацаанд засвар үйлчилгээ гүйцэтгээгүйн улмаас учирсан хохирол;
16. Аюулгүй ажиллагааны аливаа дүрэм, журам зөрчсөнөөс учирсан хохирол;
17. Зөвшөөрөлгүйгээр барилгын хийц хэсгийг өөрчилснөөс учирсан хохирол;
18. Үл хөдлөх хөрөнгийг зориулалтын бусаар ашигласнаас үүдэн гарах хохирол;
19. Даатгалын зүйлийн өмчлөлд өөрчлөлт орсон талаар даатгагчид 30 хоногийн дотор мэдэгдээгүй үед учирсан хохирол;
20. Хууль, журам, гэрээний үүргээ зөрчсөн бусад үйлдэл;
21. Учирсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн хохирол, олох ёстой байсан орлого болон бусад үр дагавар;
22. Даатгалын гэрээнд зааснаас бусад эрсдэл;
23. Даатгалын эрсдэлийн улмаас даатгалын зүйлийн байршиж буй газар, шороо, хөрс, агаар, газрын хэвлийн болон байгаль орчинд учирсан хохирол;
24. Цацраг идэвхит бодисын хордлого, бохирдолт зэргээс учирсан хохирол, үр дагавар;
25. Цөмийн эрсдэл;
26. Дайн байлдаан, үймээн самуун, бослого, ажил хаялт, улс төрийн болон террорист үйл ажиллагааны үр дагавар;
27. Даатгагчтай тохиролцолгүйгээр хохирлын бодит хэмжээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдол;
28. Даатгуулагчийн өөрийн алдаа, хайхрамжгүй үйлдэл, эс үйлдлээс даатгалын хохирлыг буруутай этгээдээс нэхэмжлэх боломжгүй болгосон.